

Тус газар нь аймгийн Засаг даргын 2023 оны А/73 дугаар “Бүтэц орон тоо батлах тухай” захирамжаар 65 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар батлагдсан.

Аймгийн төвд 35 орон тоо, сумдад 30 ажилтан албан хаагч байхаас 2026 оны эхний хагас жилийн байдлаар хүний нөөцийн хэрэгцээ шаардлагын дагуу сул байсан дараах 8 ажлын байранд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, ажилтан томилон орон тоог нөхөн ажиллалаа.

Үүнд сумдад (нийт 4 орон тоонд): спортын арга зүйч-2, үйлчлэгч-2, аймгийн төвд (Нийт 4 орон тоонд) Маркетинг, нийтлэг үйлчилгээний ажилтан-1, жижүүр-3 ажлын байранд албан хаагч, ажилтныг томилон ажиллуулж байна.

Одоо сул байгаа 6 орон тооны мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн албан ёсны цахим хуудас (csc.gov.mn) болон байгууллагын албан ёсны цахим хуудас www.dornogobi.sport.gov.mn болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж, аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт хүргэн иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод зарлан ажиллаж байна.